



“Биеэ даасан сүсэг бишрэлийг зорьцгооё”

Рисшо Косей Кай, Ерөнхийлөгч
Нивано Ничикоо

80 жилийн ойгоор дамжуулж байгууллагын үндэс суурийг
тавьсан ахмад багш нарын ачийг хариулахаа тангараглая



Та бүхэнд шинэ жилийн мэнд хүргэе.

Би өнгөрсөн жилийн зорилтыг “Талархах сэтгэлээ өдөр тутмын амьдралдаа илэрхийлж, хэрэгжүүлцгээе” хэмээн тодорхойлсон. Гишүүд үүнийг өөрийн зорилго болгон ажил, гэр бүл, нийгмийн амьдралдаа хэрэгжүүлсэн болохыг салбарын тэргүүн болон бусад олон хүнээс сонссон. Мөн Их ариун ордонд тавигдсан гишүүний илтгэлээс ч гэсэн сонссон.

Шагжамүни буддагийн сургаалын гол санаа “бүх зүйлд талархах” гэдэг. Үүнийг цаашид ч гэсэн үргэлж сэтгэлдээ бясалгаж, хэрэгжүүлэх хэрэгтэй гэж бодож байна.

Энэ жилийн хувьд манай байгууллага 80 жилийн ойтой золгоод байна. 80 жилийн дотор Үүсгэн байгуулагч 54 жил, би 26 жил ерөнхийлөгчийн үүргийг гүйцэтгэсэн.

Энэ хугацааг товчхон дүгнэвэл Үүсгэн байгуулагч ч гэсэн, би ч гэсэн бурханы сургаалыг тууштай түгээж, гишүүд түүнийг ул суурьтай хүлээн авч, хэрэгжүүлж ирсэн гэж хэлж болно.

Үүсгэн байгуулагч тус байгууллагыг байгуулж, сургаал ном дэлгэрч эхэлсэн үе бол дайны өмнө, дайны ид үе, дайны дараа гэсэн нийгмийн тогтворгүй цаг үе байсан. Тухайн үед хүмүүс юуны түрүүнд ядуурал, өвчин

зовлон, дайны аюулаас л зугтахыг хүсдэг байсан. Түүнчлэн ахмад гишүүд өөрсдөө зовлон бэрхшээлээр дүүрэн байсан хэдий ч хааяа эелдэг зөөлөн, хааяа хатуу хандан уран арга хэрэглэж хүмүүсийг аварч, бурханы зам мөрд хөтлөн оруулж байсан.

Дээр үеийн ахмад багш нар олон юм нуршилгүй, товч тодорхой үгээр хүний сэтгэлийг татах увидастай байсан. Гишүүнээ цааш нь түлхэж буй мэт үйлдэл байсан ч гэсэн түүний цаана нөгөө хүнийхээ аз жаргалын төлөө чин сэтгэлээсээ залбирах гүн гүнзгий энэрэн нигүүлсэх сэтгэл байсан.

Ийнхүү “хүмүүсийг ямар нэгэн аргаар аз жаргалтай болгох юмсан” гэсэн энэрэн нигүүлсэх сэтгэл үе уламжлагдан явсаар өнөөдрийн Косей кай байгууллагын үндэс суурь болсон билээ.

Би ахмад багш нартаа талархах сэтгэлээр “2018 оны зорилт”-ыг дараах байдлаар тодорхойллоо.

Байгаль дэлхий хором мөч бүрт бүтээн байгуулалт, өөрчлөлт шинэчлэлтийг хийж байдаг. Бид ч гэсэн энэхүү байгаль дэлхийн зохилдлогооны дагуу нэг газраа зогсолгүй, аливаа зүйлд үргэлж шинэлэг бүтээлч сэтгэлээр

хандах чухал.

Үүсгэн байгуулагч, Мёокоо багштан болоод ахмад багш нар, гишүүд өдөр шөнөгүй хичээж зүтгэсний ачаар байгууллагын 80 жилийн түүх сүндэрлэн боссон билээ.

Тэдний ачийг хариулахын төлөө, энэхүү тэмдэглэлт жилээр дамжуулан, байгууллагын 100 жилийн ойг зорин хүн бүр шинийг бүтээнэ гэсэн хатуу зорилго тавин урагшилахыг уриалж байна.

Товчхондоо ахмад багш нарынхаа ачийг хариулахын зэрэгцээ байгууллага ч, хувь хүн ч үргэлж “бүтээлч байх”-ыг эрмэлзэх чухал юм.

Энэ талаар «Хуай нан зи /Huai-nan-zi/» хэмээх Хятадын эртний судар бичигт сонирхолтой зүйл бичсэн байна.

“50 насандаа өмнөх 49 жилийн амьдралаа эргэн дүгнэж, дахин шинээр эхэл. 60 хүрээд насандаа таарсан өөрчлөлт шинэчлэлтийг хийвэл зохилтой.”

50, 60 нас гэдэг бол хүн тодорхой хэмжээнд боловсорч гүйцэх нас. Хэдий тийм ч гэлээ шинийг эрэлхийлэх сэтгэлээ маргалгүй, үргэлжлүүлэн өсөж хөгжих чухал. Үүнийг шинэлэг, бүтээлч гэх ба ямар ч насны хүнд хамаатай зүйл болов уу гэж бодож байна.

Бүтээлч амьдрах хүсэл эрмэлзэл хүн бүхэнд байдаг.

Түүнийгээ анзаарч, хэрэгжүүлэхэд л хангалттай.

“Бүтээлч” гэдэг үг бодит амьдрал дээр нэг л хол санагддаг бололтой. Толь бичгээс харвал “байгаагүй зүйлийг шинээр хийх” гэсэн байна. Энэ утгаараа хэцүү зүйл гэж бодогдох нь аргагүй.

Миний хувьд “бүтээлч” гэдгийг илүү ойрхон хүлээж авдаг. Өвс ургамал өдөр өдрөөр бага багаар өсөж ургадагтай адил “өглөө гэрийнхэнтэйгээ мэндчилж сурлаа”, “ийм зүйлийг анзаарлаа”, “өчигдрийнхөөсөө илүү хөгжлөө” гэдэг нь л тухайн хүний хувьд “шинийг бүтээсэн” гэсэн үг гэж бодож байна.

Угтаа хүн бүхэнд улам илүү өсөж хөгжих юмсан гэсэн сэтгэл байдаг гэдэг. Цаашлаад илүү дээд түвшний, эрхэм, агуу зүйлийг хийж бүтээе гэсэн байгалийн хүсэл байдаг байна.

Өөрөөр хэлбэл ямар ч хүнд бүтээлч амьдрах

хүсэл эрмэлзэл нуугдсан байдаг тул түүнийгээ анзаарч, хэрэгжүүлэхэд л болох юм.

“Хүсэл эрмэлзэл” гэдэг ханзыг бичихдээ арвын тоон доор нэгийн тоо бичиж, түүний доор сэтгэл гэдэг ханз бичдэг. Арвын тоо нь хүнд маш их байдаг хүсэл шуналын сэтгэлийг илэрхийлж байгаа ба нэгийн тоо нь тэр олон хүслээ нэгтгэн цэгцлэх гэсэн утгатай.

Ингэмээр байна, тэгмээр байна хэмээн сэтгэл хоёрдсон байх юм бол урагш ахиж чадахгүй. Тиймээс эхлээд гол зорилгоо тодорхойлж, түүндээ төвлөрч хэрэгжүүлэх чухал гэсэн үг юм.

Гол зорилгодоо хамаг хүчээ зориулж, хийж гүйцэтгэснийхээ дараа дараагийн шинэ зорилгохынхоо төлөө хичээх. Үргэлж шинэлэг, бүтээлч байх гэж үүнийг хэлнэ.

“Хүнийг хөгжүүлэх” асуудалд бүх хүчээ зориулах нь бидний үүрэг

20 жилийн өмнө байгууллагын 60 жилийн ойгоор “Хүн бүрийн сэтгэлийг хөгжүүлэх Косей Кай” гэсэн ерөнхий зорилт тавьсан. Энэ 20 жилд шинийг бүтээж, зорилтынхоо дагуу баттай урагшилж чадсан билээ.

Түүнчлэн 70 жилийн ойг тохиолдуулан бүх гишүүнийд Гол шүтээн залах ажлыг өрнүүлж эхэлсэн. Үүгээр дамжуулж айл бүрт Мөргөлийн гурван эрдэнэ гэсэн буддын шашны үндсэн хэлбэр төрх хэлбэрээ олсон. Түүнээс хойших 10 жилд бурхан тахилаа хүндлэн дээдэлдэг гэр бүл мэдэгдэхүйц нэмэгдэж, энэ ойлголт тогтож ирсэн.

Дээрх үйл явцыг тусгаж үзсэний үндсэн дээр 100 жилийн ой буюу байгууллага үүсгэн байгуулагдсаны 1 зууны ойг угтан бидний хийх чухал ажил бол боловсон хүчин бэлдэх буюу хүний хөгжил гэсэн үндсэн асуудалд бүх хүчээ зориулах явдал гэж бодож байна.

Тэгвэл ямар хүнийг хөгжүүлбэл зохилтой юм бол? Мэдээж хэрэг “Бурхан багш болон Үүсгэн байгуулагч, Мёокоо багштан шиг энэрэн нигүүлсэх сэтгэл буюу хүнлэг сэтгэл (гэгээлэг, эелдэг, зөөлөн дулаан)-ээр бодисадвагийн зам мөрөөр алхах хүн”-ийг хөгжүүлэх юм.

Ийм хүнийг бэлдэхийн тулд “судар уншлага”, “мичибики, тэдори, хооза”, “сургаал номд суралцах” гэсэн “Сүсэг бишрэлийн гурван үндсэн үйл”-ийг тууштай хэрэгжүүлэх чухал.

Эдогийн хожүү үеийн нэрт сэтгэгч Ниномия Такаоригийн “Намар болохоор бороо орж, салхи шуурга дэгдээд ургац яах бол гэж санаа зовоодог. Гэвч яг одоо хийж чадах зүйл бол зэрлэг өвсийг зулгаах юм” гэсэн утгатай шүлэг байдаг.

Энэ шүлэг нь бид яг одоо юу хийх чухал вэ гэдгийг сануулдаг.

Би ч бас будаа тарьж байсан удаатай. Үр суулгаснаас хойш нэгээс хоёр долоо хоногийн дараа зэрлэгийг зулгаадаг. Зэрлэгийг зулгаахдаа эхнийх, хоёр дахь, гурав дахь удаа гэж гурван удаа зулгаах хэрэгтэй байдаг. Зулгаасан зэрлэгийг хаялгүй тариан талбайн шаварт хольж хийдэг. Ингэснээр зэрлэг нь бордоо болдог байна.

Үүнтэй адил хүнийг хөгжүүлэхэд “Сүсэг

бишрэлийн гурван үндсэн үйл”-ийг шантралгүй дахин давтан хийх чухал. Үүний зэрэгцээ гэр бүл, санга нар бие биенээ дэмжиж, бие биенээсээ суралцаж, хамтдаа өсөж хөгжиж явсаар “намрын ургац”-аа хураадаг билээ.

Хүн гэдэг болоогүй зүйлд санаа зовоод яг одоо хийх ёстой зүйлдээ анхаарлаа хандуулж чаддаггүй.

Гэвч бидний амьдралд хамгийн чухал зүйл бол “яг одоо нүдний өмнө байгаа зүйл” юм. Яагаад гэвэл бидний зарцуулж чадах цаг бол өнгөрсөн ч биш, ирээдүй ч биш “яг одоо” юм. Яг энэ хором мөчид хийх ёстой зүйлийг чин сэтгэлээсээ хийж, тэр нь хуримтлагдсаар амьдрал үр бүтээлээр дүүрэн болдог.

Би саяхныг хүртэл байгууллагын 100 жилийн ойг болоогүй байна гэж бодож байсан. Гэвч 20 жилийн дараа гээд бодохоор нилээн дөхчихсөн юм байна гэж бодогдож байна.

Өнөөдрийг хүртэл би “Шагжамүни буддагийн бидэнд дамжуулахыг хүсэж байсан гол санааг ухаарцгаая” хэмээн хэлж байсан.

Өөрөөр хэлбэл яг одоо ямар их ач тусыг хүртсэн болохоо ухаарч, сэтгэлд таагүй зүйлээр дамжуулж Бурхан юуг сургаж байгааг анзаарах. Бусад хүмүүстэй хамтдаа аз жаргалтай болох нь жинхэнэ аз жаргал гэдгийг ухаарах. Бусад хүмүүст түшиглэсэн сүсэг бишрэлээс үлгэр дуурайл, биеэ даасан сүсэг бишрэл рүү шилжиж, “өөрөө зул мэт гэрэлтэж, сургаалыг зул мэт сэтгэ” хэмээх сургаалыг хэрэгжүүлэх. Товчхондоо эдгээр нь Шагжамүни буддагийн айлдсан жинхэнэ аз жаргал бөгөөд “сэтгэлээ хөгжүүлэх” явдал юм.

Байгууллагын 100 жилийн ойг зорин гишүүд маань жинхэнэ бурханы шавь, жинхэнэ сүсэг бишрэлтэй хүн болж өсөж хөгжөөсэй хэмээн хүсэж байна.

Би ч гэсэн та бүхэнтэй хамт “яаралгүй гэхдээ амралгүй”, ямар ч үе, ямар ч нөхцөл байдалд сэтгэлээ хөгжүүлэхийг зорих болно.

New Year's Issue
2018

Living the LOTUS

Buddhism in Everyday Life

